



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ

11
АНГИ

ТҮҮХ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:



САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

1. Зүүн гарын хаант улсыг 1671-1697 онд захирч байсан анхны хаан хэн бэ?
A. Галданцэрэн хаан B. Цэвээнравдан хаан
C. Даваач хаан D. Галдан бошигт хаан
2. 1912 онд байгуулагдсан Монголын анхны иргэний бага сургууль анх хэдэн сурагчтай үйл ажиллагаагаа эхэлсэн бэ?
A. 47 B. 32 C. 100 D. 17
3. Манжууд аль Монголчуудтай худ ургийн холбоог эхлэн тогтоож, өөртөө татах бодлого баримталж байсан бэ?
A. Халх Монгол B. Өвөр Монгол C. Зүүнгар улс D. Хошууд улс
4. Монголчууд харийн эрхшээлд ороход нөлөөлсөн дотоод шалтгааныг олно уу.
A. Монголын их хааны сүр хүч суларч, монголчууд олон хэсэгт хуваагдсан
B. Мин улсын хагалан бутаргах бодлого нөлөөлсөн
C. Манж улс хагалан бутаргах, эзлэн түрэмгийлэх бодлогоо идэвхжүүлсэн
D. Хаант Орос улс газар нутгаа тэлэх бодлого явуулж байсан
5. Цэгийн оронд тохирох утгыг нөхөж бичнэ үү.
1905 оны намар Өвөр монголын Жирмийн чуулганы өмнөд Горлос хошуунд
..... удирдлагаар зэвсэгт бослого гарчээ.
A. Онолтын B. Цогдалайн C. Чингүнжавын D. Тогтох тайжийн
6. Тогтох тайж ямар шалтгаанаас болж хятад худалдаачид, мөнгө хүүлэгчдийн пүүсийг эвдэн сүйтгэж, өрийн дансыг устгасан бэ?
A. 1756 онд Чин ван Эринчиндоржийг Амарсанаагийн хэрэгт холбогдуулан цаазаар авснаас
B. Бүрни, Лувсан нар 1675 онд Манжийн ноёрхлыг эсэргүүцэн босож тэмцээд амь үрэгдсэнээс
C. Өвөр Монголд Хятадын мөнгө хүүлэгч, худалдаачдын мөлжлөг хэрээс хэтэрснээс
D. 1758 оны эцэс хүртэл Зүүнгарын босогчид хэсэг бүлгээр тулалдсанаас
7. 1689 онд Ар элстэйн чуулганд Халхын ноёдыг Манж Чин улсад дагаар орохыг уриалсан хүн хэн бэ?
A. Цэвээнравдан хаан B. Өндөр гэгээн Занабазар
C. Манжийн Энх-Амгалан хаан D. Галдан бошигт хаан
8. 1689 оны Нэрчүгийн гэрээгээр Эрхүү, Түнхэний шивээ орчмын нутгийг, хүн амын хамт аль улсын эрхшээлд оруулахаар болсон бэ?
A. Манж Чин улсын B. Оросын хаант улсын
C. Зүүн гарын хаант улсын D. Төвөд улсын
9. Манжийн эрхшээлийн үед Монголын нийгмийн дээд давхаргад ямар хүмүүс ордог байсан бэ?
A. хамжлага B. шавь C. албат ард D. тайж


10. Манжийн эрхшээлийн үед Монголын ноёд тайж нарын харьяат ардыг юу гэдэг байсан бэ?

- A. хамжлага В. шавь С. тайж D. хутагт лам

11. Богдын тэргүүлсэн засгийн газрын үйл ажиллагаанд аль нь хамаарах вэ?

- A. Цагаантны цэрэгт хүчин зүтгэж байсан монголчуудыг талдаа татах
 В. МАН, Түр засгийн төлөөний түшмэлийг хошуу, шавьд томилон суулгахаар шийдсэн нь
 С. Ардын журамт цэргийг өргөтгөх, хүч нөлөөгөө нэмэгдүүлэх
 D. АТЗГ-тай сэргэлдэж байсан тул яваандаа зэвсэгт мөргөлдөөнд зайлшгүй хүрнэ хэмээн бэлтгэлээ хангаж байсан нь

12. Цэгийн оронд тохирох үйл явдлыг нөхнө үү.



- A. Хятадын ерөнхийлөгч Монголын автономийг цуцлах зарлиг гаргав. Монголд үндэсний телевизийн нэвтрүүлэг эхлэв.
 В. Засгийн газраас төр шашны хэргийг тусгаарлан явуулах тухай хууль баталжээ. Атрын анхдугаар аян өрнөв.
 С. Монгол Улсад Бүгд Найрамдах засаглал тогтов. НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болов.
 D. Хамжлагын харилцааг халах шийдвэр гаргав. БНМАУ гурав дахь Үндсэн хуулиа батлав.

13. Монголын ард түмний хөрөнгөөр ЗХУ-д захиалан хийлгэж, Улаан армид бэлэглэсэн “танкны бригад”-ын нэр юу вэ?

- A. Хөх Монгол В. Хувьсгалт Монгол
 С. Бүхнийг фронтод D. Монгол Ард

14. Атрын анхдугаар аян хэдэн оноос эхэлсэн бэ?

- A. 1961 оноос В. 1976 оноос С. 1959 оноос D. 1981 оноос

15. Шинжлэх ухаан, техникийн хөгжилд аль нь хамаарах вэ?

- A. 1970 он гэхэд хүн амын 89,3% нь бичиг үсэг тайлагдсан.
 В. Сургуулийн бүтцийг 3+5+2 болгон өөрчилсөн.
 С. Монголын эрдэмтэд сансар судлалын “Интеркосмос” программыг хэрэгжүүлэх ажилд гар бие оролцсон.
 D. 1988 онд “Мандухай сэцэн хатан” кино дэлгэцнээ гарсан.

16. БНМАУ 1965 онд Франц улстай дипломат харилцаа тогтоосон ба энэ жил дипломат харилцаа тогтоосны хэдэн жилийн ой болох вэ?

- A. 59 жилийн ой В. 57 жилийн ой С. 58 жилийн ой D. 61 жилийн ой

17. 1913 оны 11 сарын 8-нд Бээжинд Хаант Орос улс, Дундад Иргэн улсууд “Монголын тухай тунхаг бичиг” гаргажээ. Энэ үйл явдал “Олноо өргөгдсөн”-ий хэддүгээр онд болсныг тооцоолно уу.

- A. 5 дугаар онд В. 4 дүгээр онд С. 3 дугаар онд D. 1 дүгээр онд

25. Цэгийн оронд тохирох утгыг нөхнө үү.

Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь-ыг хангах үндэс билээ.

А. мэдээллийн аюулгүй байдал

В. дотоод аюулгүй байдал

С. хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал

Д. хүний аюулгүй байдал

26. Цэгийн оронд тохирох үйл явдлыг нөхнө үү.



А. Монголд анх удаа чөлөөт ардчилсан сонгууль явагдав. Өмч хувьчлал эхлэв.

В. МоАХ байгуулагдав. Шинэ Үндсэн хуулийг батлав.

С. Газрын тухай хууль батлав. Хэвлэлийн мэдээллийн эрх чөлөөний тухай хууль батлав.

Д. Бурхан багшийн чандрыг Монголд залав. “Монгол Улсын Түүх” 5 боть бүтээл гаргав.

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ, ДААЛГАВАР

2.1. Монголын түүхийн үечлэлийг үйл явдалтай нь зөв харгалзуулаарай.

а. Монголын эзэнт гүрний үе	1. Шинэ засгийн бодлого хэрэгжүүлэв.
б. Манжийн эрхшээлийн үеийн Монгол	2. Тангаргийн гэрээг батлав.
с. Богд хаант Монгол улсын үе	3. УБ хотод 4-р цахилгаан станц барив.
д. БНМАУ-ын үе	4. Үндсэн хуулийн цэц байгуулагдав.
е. Монгол улсын үе	5. Юань улс “Цаасан мөнгө” гаргав.

2.2. БНМАУ-ын нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, бодлогуудтай холбоотой үйл явдлыг зөв харгалзуулаарай.

а. Шинэ эргэлтийн бодлого	1. МАХН марксизм-ленинизмын онолыг нийгмийн хүрээнд тулган хүлээлгэв.
б. Нийгмийн амьдралд гарсан өөрчлөлт	2. 1959-1960 онд 18.5 тонн төмс хураан авав.
с. Эдийн засагт гарсан өөрчлөлт	3. Орны цагаан хэрэглэл хэрэглэдэг болов.
д. Атрын анхдугаар аян	4. Нэг нэгдэл дунджаар 43 мянган малтай байв.
е. Соёлын довтолгоо	5. 1932 оны 6-р сарын 29-30 МАХН-ын ТХ, Хянан байцаах Төв Комиссын хамтарсан онц III бүгд хурал хуралдав.

2.3. Ардчилсан Хувьсгал ялснаас хойш Монгол Улсад гарсан өөрчлөлтийг хууль цаг хугацаатай нь зөв харгалзуулаарай.

а. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоог халав.	1. 1994 он
б. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль батлав.	2. 1998 он
с. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр	3. 1991 он
д. Гадаад бодлогын үзэл баримтлал батлан гаргав.	4. 1990 он
е. МУ-ын Иргэний хуулийг шинэчлэн, иргэд хувийн өмчтэй байхыг хуульчлан батлав.	5. 1996 он